# ХАМТДАА ИХ ЗҮЙЛИЙГ БҮТЭЭЖ ӨӨРЧЛӨЛТИЙГ БИЙ БОЛГОЦГООЁ!

# SERVE TO CHANGE LIVES

2021-2022 Ротарийн Жилийн 1-р улиралын цахим сонин

Rotary Clubs of Mongolia | SERVE TO CHANGE LIVES    Rotaract    Interact

## Олон Улсын Ротарийн 2021-2022 оны Ерөнхийлөгч Шекар Мехтагийн Ротарийн шинэ жилийн мэндчилгээ

*Танд болон таны гэр бүлд Ротарийн шинэ жилийн мэнд хүргэе!*

*Энэ жил бидний амьдралын хамгийн сайхан жилүүдийн нэг байхын төлөө Хамтдаа ихийг хийж өөрчлөлтийг авчирцгаая.*

Shekhar Mehta



## Олон Улсын Ротарийн 3450 дүүргийн захирагчийн мэндчилгээ



2008 онд Ротарийн гишүүнд элссэн өдрөө эргэн дурсахад нэгэн арван жилийг энэхүү том гэр бүлд өнгөрүүлсэн байна. 13 жилийн өмнө би өөрийгөө өөрийн гэр бүлийн кэйтерингийн үйлчилгээний компаний Хүний нөөц-Бизнес хөгжлийн дарга гэж танилцуулж байсан, 2014 онд Адмиралти Ротари Клубын Ерөнхийлөгч хэмээн өөрийгөө танилцуулж байсан, харин өнөөдөр ОУРотарийн 3450 Дүүргийн Захирагч хэмээн эргэлзэлтгүйгээр танилцуулж байна.

Миний хувьд Ротари бол манай Ротарийн лого мэт маш том хөдөлгүүр гэлтэй. Хүн бүр энэ бүхний нэгээхэн хэсэг нь гэхээсээ илүү хөдөлгөгч хүч нь юм. Тиймээс хувь хүн бүрийнхээ хувьд бид ээлж дарааллаараа энэхүү системийг тасралтгүй ажиллуулах үүргээ төгс гүйцэтгэх хэрэгтэй.

Манай ОУ-ийн Ерөнхийлөгч Шехар Мэхта Хүн бүр – Нэг Гишүүн уриа дэвшүүлсэн байгаа бөгөөд би ч мөн та бүхнийг бидний үйл ажиллагаанд найз нөхөд, гэр бүлийн гишүүдээ урьж оролцуулаарай гэж уриалмаар байна.

Би Дүүргийн Захирагчаар 20-21 онд ажилласан Эрик Чак болон түүний баг хамт олонд чин сэтгэлийн талархал дэвшүүлэхийг хүсэж байна. Хийж буй зүйл хэлж буй үгнээс чанга ярьдаг гэдэг. Бүтээлч байцгаая гэж уриалж байна. Бид өнгөрсөн Ротарийн жил боломжуудаа нээсэн, одоо 3450 Дүүргийн гишүүн бүр амьдралыг өөрчлөхийн төлөө үйлчилцгээе.

3450 Дүүргийн 21-22 оны Захирагч
**КЕЙТ ЧОУ**

## ОЛОН УЛСЫН РОТАРИ 3450 ДҮҮРГИЙН 9, 10 БҮСИЙН ЗАХИРАГЧ НАРЫН МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм хүндэт Ротаричууд, Ротарактууд, Интерактууд болон Ротарийг дэмжигчид та бүхэндээ 2021-22 оны Ротарийн Шинэ жилийн мэндийг уламжлан мэндчилье.

Дэлхий нийтэд Ковид-19 цар тахал тархаж, хүн төрөлхтний өмнө сорилт тулгарсан энэ цаг үед Ротарийн үнэт зүйлс, эрхэм зорилго улам бүр ач холбогдолтой болж, түүнчлэн Монголын Ротаричуудын үйл ажиллагаа эрч хүчтэй, амжилттай явж байгаад Бүсийн Захирагч бидний зүгээс та бүхэндээ талархал илэрхийлье.




2021-22 оны Ротарийн жилд Монголын 9,10-р Бүсүүд нийт 17 Ротари клуб, 15 Ротаракт клуб, 7 албан ёсны Интеракт клубын 1000 гаруй гишүүдтэйгээр 2021-22 Ротари жилийн үйл ажиллагаагаа эхлүүлээд байна.

2021-22 оны Ротарийн жилд Дүүргийн болон Бүсийн хэмжээнд доор дурьдсан
5 үндсэн чиглэлээр үйл ажиллагаагаа чиглүүлж ажиллана. Үүнд:
1. Гишүүнчлэлээ нэмэгдүүлж гишүүн бүр 1 гишүүн элсүүлэх,
2. Залуучуудын хорооны ажилд онцгой анхаарч ажиллах, Ротаракт клубын гишүүдийг Ротарийн статус бүхий гишүүн болгоход бэлтгэж ажиллах,
3. Ротарийг олон нийтэд илүү их сурталчилах,
4. Олон Улсын Ротарийн санд хандиваа өгч илүү их өөрчлөлтийг авчрах боломжуудыг олж харах,
5. Эрүүл мэндийн чиглэлээр дэвшүүлсэн хөтөлбөр, аянуудад идэвх гарган амжилттай оролцох,

2020-21 оны Ротарийн жилд Бүсийн Захирагчдын зүгээс Жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөгөө урьдчилан гаргаж Дүүргийн Захирагч болон Санхүүчээр баталгаажуулж ажиллаж байгаа нь бас энэ жилийн нэг онцлог үйл явдал юм.

Бүсийн Захирагчдын хувьд нийт Ротарийн гэр бүлийн гишүүн бүрийнхээ нийгмийн төлөө хийж буй сайн үйлс бүхнийг дэмжин ажиллахаа илэрхийлж, бусдын сайн сайхны төлөө хийж буй эрхэм нэр хүндтэй сайн үйлсэд тань улам их амжилт хүсье.
Монголын Ротаричууд улам олуулаа болж, хамтдаа их зүйлийг бүтээж өөрчлөлтийг бий болгоцгооё!

Хүндэтгэсэн,
Олон Улсын Ротарийн 3450 Дүүргийн 9 дүгээр бүсийн захирагч
**Н.Мягмаржаргал**

Хүндэтгэсэн,
Олон Улсын Ротарийн 3450 Дүүргийн 10 дугаар бүсийн захирагч
**Т.Болормаа**

# ШИНЭ РОТАРИЙН ЖИЛ

## 2021-2022 ОНЫ РОТАРИ ЖИЛИЙН УРИА

**SERVE TO CHANGE LIVES**

**АМЬДРАЛЫГ ӨӨРЧЛӨХИЙН ТӨЛӨӨ ҮЙЛЧИЛЦГЭЭЕ**

We are CHANGEMAKERS

Бид бол ӨӨРЧЛӨЛТИЙГ АВЧРАГЧИД

## 2021-2022 ОНЫ ОУ РОТАРИЙН 3450 ДҮҮРГИЙН 9, 10 БҮСИЙН УДИРДЛАГЫН БАГ

| | |
|---|---|
| Дүүргийн Захирагчийн зөвлөх | PAG Бэрцэцэг |
| Бүсийн Захирагч, 9-р Бүс | AG Мягмаржаргал |
| Бүсийн Захирагч, 10-р Бүс | AG Болормаа |
| DAG 9-р Бүс/ PI | Сальма |
| DAG 9-р Бүс | Эрдэнэбаяр |
| DAG 10-р Бүс/ DDS | Кема |
| DAG 10-р Бүс | Галбадрах |
| Сангийн хорооны дэд дарга | PAG Мөнхжаргал |
| Гишүүнчлэлийн хорооны дэд дарга | IPAG Дамдиндорж |
| Залуучуудыг дэмжих хорооны дэд дарга | PP Ариунгоо |
| Олон нийтэд таниулах хорооны дэд дарга | DAG Сальма |
| Эрүүл мэндийн хорооны дэд дарга | PP Батгэрэл |
| Төслийн хорооны дэд дарга | PAG Жамбалмаа |
| Байгал орчин хамгаалах хорооны дэд дарга | PAG Цэрэнчимэг |
| Энх тайвны хорооны дэд дарга | PAG Энхтуяа |
| Сургалтын хорооны дэд дарга | PAG Булган |
| IT хорооны дэд дарга | IPAG Бат-Эрдэнэ |
| Интеракт хариуцсан хорооны дэд дарга | PP Чимэдням |
| Спорт болон Арга хэмжээний хорооны дэд дарга | PP Гантулга |
| Нөхөрлөлийн хорооны дэд дарга | PAG Ганбат |
| DDRR 9 бүс | RAC PP Бэрцэцэг |
| DDRR 10 бүс | RAC PP Дөлгөөн |
| DDRC 9, 10 бүс | IPP Номуунбилэгт |

## ОУ РОТАРИ БОЛОН ДҮҮРГИЙН ГОЛ ЧИГЛЭЛҮҮД

Membership
**ГИШҮҮНЧЛЭЛ**




Health
**ЭРҮҮЛ МЭНД**



Youth
**ЗАЛУУЧУУД**



Public Image
**ОЛОН НИЙТ**




TRF
**РОТАРИ САН**




| ШИЛДЭГ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ШАЛГУУРУУД | |
|---|---|
| JPM ийн оролцоо | Жилийн төлөвлөгөөгөө гаргах |
| Rotary сурталчилж Socialууд дээр мэдээлэл сард доор хаяж 1 удаа мэдээлэл өгөх | PETS ийн оролцоо |
| My Rotary дээр ирэх жилийн бүх хороодын даргаа оруулсан байх | Online академид клуб бүр 50% ийн оролцоо |
| My Rotary дээр Зорилго оо оруулах | Сар болгоны тайлангаа өгөх |
| MOU гаа зурж явуулах | Foundation Giving - Ротари санд хандив өгсөн байдал |

| ШИЛДЭГ КЛУБЫН ШАЛГУУРУУД | |
|---|---|
| Сар болгоны клубын хурал | AG Visit |
| Шинэ гишүүн нэмэх 2 оос дээш | DG Visit |
| Татвараа цагт нь төлөх | Спортын арга хэмжээний оролцоо |
| Бусад клубуудтай хамтарсан үйл ажиллагаа | Шинэ жилийн арга хэмжээний оролцоо |
| RAC тай хамтарч төсөл эсвэл арга хэмжээний оролцоо | PPE болон Ногоон төслийн оролцоо |
| Дүүргийн голлох чиглэлийн төсөл хэрэгжүүлсэн байдал | End Polio өдөрлөгийн оролцоо |
| Сангийн сургалтын оролцоо | Clean up day өдөрлөгийн оролцоо |
| Гишүүнчлэлийн сургалтын оролцоо | Rotary Day ийн оролцоо |
| PI сургалтын оролцоо | Клубын зүүгээ солилцох |
| Залуучуудын хорооны сургалтын оролцоо | Азийн Конференцийн оролцоо |

**1. Оны Шилдэг Ерөнхийлөгч тодорхойлох (3), 2. Оны шилдэг Клуб (1)** Жич: Бүс тус бүр дээр

# БҮСИЙН ЗАХИРАГЧДЫН АЙЛЧЛАЛ



**Номт Ротари Клуб, УБ Централ Клуб**
**Цахим Айлчлал**



**Тамир**
**Ротари Клуб**



**Нарлаг Улаанбаатар**
**Ротари Клуб**



**Хүрээ**
**Ротари Клуб**



**Улаанбаатар**
**Ротари Клуб**



**Улаанбаатар Пийс Авеню**
**Ротари Клуб**




**Тэнгэр**
**Ротари Клуб**



**Гэрэгэ**
**Ротари Клуб**




**Сэлэнгэ**
**Ротари Клуб**



**Зуунмод**
**Ротари Клуб**

# БАХАРХАЛТ МОНГОЛ

**Энэ жилийн бүх татваруудаа, клубын зорилт зорилгуудаа болон чухал бичиг баримтуудаа заасан хугацаанд багтан төлж гүйцэтгэсэн бүх клубүүддээ БАЯРЛАЛАА.**
9,10 Бүсийн БҮХ КЛУБУУД: 100%

- Дүүргийн Татвар
- Олон Улсын Татвар
- Ротари Зорилтууд ба жилийн төлөвлөгөө

- Сангийн Бичиг баримтууд ба сургалтууд
- Зүүсгэл Солилцох/Ассемблэй
- Төслийн бэлтгэл ажлууд

**КЛУБУУД ЗҮҮСГЭЛЭЭ СОЛИЛЦОЖ ШИНЭ ЕРӨНХИЙЛӨГЧ БОЛОН УДИРДЛАГЫН БАГУУДАД АМЖИЛТ ХҮСЭЭ.**
























# ЫН РОТАРИ КЛУБУУД

## КЛУБУУДЫН ТӨСЛҮҮД















## КЛУБУУДЫН ХӨГЖӨӨНТ НӨХӨРЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАНУУД







# БИДНИЙ ШИНЭ ХАМТЫН АЖИЛЛАГАА

**Оу ротарийн 3450 дүүргийн 9, 10 бүсүүд болон улаан загалмайтай хамтран ажиллах санамж бичиг**






**Оу ротарийн 3450 дүүргийн 9, 10 бүсүүд болон дэлхийн зөн монгол байгуулагатай хамтран ажиллах санамж бичиг**







**ОУ Ротарийн 3450 Дүүргийн 9, 10 бүсүүд болон Цус Сэлбэлт Судлалын Үндэсний төвтэй хамтран ажиллах санамж бичиг байгуулж сар бүрийн 3-ний Цусаа бэлэглэх өдөр Ротаричудаараа цусаа бэлэглэхийг уриалж байна.**





# ОНЦЛОХ КЛУБ: ЗУУНМОД РОТАРИ КЛУБ

## EACH ONE BRING ONE УРИАЛГЫГ БҮРЭН ХАНГАХАД ТУН ОЙРХОН БАЙГАА ИДЭВХ, САНААЧЛАГА БОЛОН БУСДЫН ТӨЛӨӨ ГЭСЭН СЭТГЭЛЭЭР ДҮҮРЭН ХАМТ ОЛОН

### ЗУУНМОДЫХНЫ ТУХАЙ:

2021-2022 оны Ерөнхийлөгч: Бадамцэцэг
Зуунмод Ротари клуб нь 2003 оны 7-р сард үүсгэн байгуулагдаж байсан Монголын Ротари хөдөлгөөний анхны орон нутаг үүсгэн байгуулагдсан клуб юм.
Төв аймгийн Зуунмод хотод байрлдаг
2020 оноос хойш Гишүүнчлэлдээ анхаарч эхэлсэн ба сүүлийн жилүүдэд 10 хүрэхгүй гишүүдтэй явж байсан бол энэ жил шинээр одоогоор нэмцэн 8 дээр нэмээд нийт тоогоо 20 руу ойртуулна гэсэн байгаа.
Клубын тогтмол хурал: сард 2 удаа, бүрийн 15/30



### МАНАЙ ЗУУНМОДЫХАН 3 САРЫН ДОТОР ДАРААХЬ АЖЛУУДЫГ БҮТЭЭСЭН БАЙНА:

- Нийт 19 Зорилго гаргасан байснаас 3 сарын дотор 11-ийг биелсэн байгаа
- 100% EREY клуб буюу гишүүдийн тоогоор 100$ Ротари санд хандивласан
- 1 Шинэ Paul Harris гишүүнтэй болсон: Ерөнхийлөгч Бадамцэцэг
- Ротариг олон нийтэд сурталчилах ажлыг эхлүүлж "TBS" ТВ-гээр сард 2 удаа зочиноор оролцож байгаа
- Дүүргийн болон Бүсийн БҮХ сургалтанд оролцсон
- Rotary Leadership Institute сургалтанд 1 гишүүн нь сурж байгаа
- Asia Comference-д 2 гишүүн нь бүтгүүлсэн байгаа
- COVID -19 100% Vaccinated буюу вакцинд хамрагдсан клуб болсон
- Мод тарих аянд нэгдэж 150 чацарганы мод тарьсан
- Зуунмод дахь Улаан Загалмай Нийгэмлэгтэй Хамтран ажиллах санамж бичиг зурлаа
- Зуунмод дахь Зуунмод Цусны төвтэй хамтран ажиллах санамж бичиг зурж сар бүрийн 3нд цусаа хандивлаж бусад иргэдийг уриалсанаар 9, 10 сард 57 иргэд цусаа хандивласан байна
- ERA Интеракт клуб үүсгэн байгуулах бэлтгэлийг эхлүүлж эхний сургалтуудаа амжилттай зохион байгуулсан байгаа
- RCC үүсгэн байгуулах хүсэлтээ илгээсэн байгаа
- Дэлхийн Зөн Монголиа байгууллагын "Монголчууд Монголчууддаа" аянд нэгдэж Хүүхэд ивээн тэтгэх хөтөлбөрт оролцож байгаа
- Клубээрээ 3 Төсөл дээр ажиллаж байна

### ROTARY YEAR 21-22 July- August - September- October








1. "Water well" GG project – 32,000USD өртөг бүхий төслийн бэлтгэх ажлыг эхлүүлсэн байгаа

2. Энэ жилийн "Эрхтэн шилжүүлэн суулгах" буюу "Organ Donation Week" – 7 хоногийнаяныг Зуунмод Ротари Клуб зохион байгуулагч клубээр оролцож "Эд эс эрхтэн шилжүүлэн суулгах ажлыг зохицуулах алба" -тай хамтран арга хэмжээнүүдийг зохиохоор төлөвлөж байна. Монголын бусад клубүүтэй хамтран хийх ба одоогоор 5,700 $-оор төлөвлөж байгаа

3. "Зуунмод – 100 хүүхэд" төслийг 2020 онд эхлүүлсэн бөгөөд энэ жил ч үргэлжлүүлэхээр бэлдэж байна. Пандемик болон бусад шалтгаанаар орлого муутай гэр бүлүүдийн хүүхдүүдэд өвлийн хувцасаар туслах төсөл юм.





# РОТАРИЙН ЗАЛУУ ҮЕИЙН АЖИЛСАГ САЙХАН СЭ

### "ХОББИ РОТАРАКТ КЛУБ" АЛБАН ЁСНЫ НЭЭЛТ БОЛОН "HEALTY HOBBY" ТӨСЛИЙН ХАНДИВ ЦУГЛУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

"Rotaract club of Hobby open ceremony" 2021 оны анхны олон нийтийг хамарсан арга хэмжээ 2021/08/27нд болж өнгөрлөө. Үйл ажиллагааг 2020-2021 оны IPDG Eric Chak нээж үүний араас PAG Нарантуяа, 2021-2022 оны AG Мийгаа, AG Болормаа нар үг хэлсэн. Энэхүү үйл ажиллагааны хүрээнд Хобби Ротаракт клубын нэрийн төсөл болох "Healty Hobby" төслийн хандив цуглуулах "HEALTHY HOBBY" Dance party зохион байгуулагдсан ба энэ нь хэрэгцээт хүүхдүүдийн амны хөндийн эрүүл ахуйг дэмжин сайжруулах үйлд зориулагдах юм.





### "НОМ" ТӨСӨЛ, "ЦЭЦЭЭ ГҮН" РОТАРАКТ КЛУБ (8 САРЫН 29)

"Цэцээ Гүн" Ротаракт клубийн Young Mining Professionals-тай хамран хэрэгжүүлж буй "Ном төслийн хүрээнд Нийслэлийн ерөнхий боловсролын 85-р сургуулийн номын санг бүрэн тохижуулж, нийт 1100 ном, 2 суурин компютер, 1 телевиз, 20 ширээ сандал хүлээлгэн өглөө.

### "ХҮН БҮР СУРАХ ЭРХТЭЙ" ЦАХИМ МЕНТОРШИП ХӨТӨЛБӨР

"Цэцээ Гүн" Ротаракт клубийн Young Mining Professionals-тай хамран хэрэгжүүлж буй "Ном" төслийн хүрээнд хэрэгжүүлсэн "Хүн бүр сурах эрхтэй" цахим менторшип хөтөлбөр хоёр сарын турш амжилттай зохион байгуулагдаж дууслаа. Энэ удаагийн менторшип хөтөлбөрт 11-р ангийн сурагчид хамрагдсан бөгөөд хувь хүний хөгжил, мэргэжил сонголтын талаар менторуудаасаа олон зүйлийг сурч мэдсэн гэдэгт итгэлтэй байна.










"Гадаадад тэтгэлгээр хэрхэн суралцах уу" цахим сургалыг DDRR нар амжилттай зохион байгуулж Хишигжаргал /PDDRR, Schwarzman Тэтгэлэгийн хүртэгч/ зочин багшаар оролцож туршлагаасаа хуваалцсан үр өгөөжтэй сургалт боллоо.



# ГГЭЛТ РОТАРАКТУУД БОЛОН ИНТЕРАКТУУД





Цаст Ротаракт клуб Кофе, Цэвэр агаар, эрүүл мэнд болон хандив босгох гэх олон үйл явдлаар дүүрэн "Coffee Camping" хандивийн арга хэмжээг 9 сарын 11нд амжилттай зохион байгууллаа.



**DREAM VISION ТӨСӨЛ**

Сэлбэ болон МУИС ротаракт клубууд хамтран Dream Vision төсөл амжилттай хэрэгжлээ.

Төслийн зорилго нь хотын захад амьдардаг ээжүүд, хүүхдүүдийн ажиллах, суралцах орчинг бүрдүүлэхэд туслах ба Хүүхдийн буддаг ном, үлгэрийн ном, будгийн хэрэгслүүд, Ээжүүдэд хувь хүний хөгжлийн болон англи хэлний номнууд өолон Хүүхдийн ширээ болон сандлуудыг хандивласан байна.

**"EYE SEE" төсөл**

Улаанбаатар Ротаракт клубээс санаачлан бага насны хүүхдүүдэд харааны үзлэг хийж, тэдний харааны бэрхшээлийг бууруулах зорилготой төсөл бөгөөд 6-8 насны 7,000 орчим хүүхдэд хараа зүйн олон жилийн туршлагатай мэргэжлийн нүдний эмч нар үзлэг хийж 747 орчим харааны бэрхшээлтэй хүүхдэд өөрийн хараанд нь таарсан нүдний шил тааруулж өгсөн байна.




**ИНТЕРАКТ КЛУБУУДЫН ЭРГЭН ТОЙРОНД**








# 9, 10-Р БҮСИЙН ГИШҮҮНЧЛЭЛИЙН ХОРОО

## EACH ONE BRING ONE РОТАРИЙН ГИШҮҮН БҮР ШИНЭЭР НЭГ ГИШҮҮН ЭЛСҮҮЛЭХ

Ротарийн гишүүд улам олон болж, 2022 оны 7 сарын 1 гэхэд гишүүдийн тоо 1,300,000-аар нэмэгдэнэ гэж төсөөлвөл:
- Бусдын төлөө зүтгэх гишүүд илүү олон болно.
- Амьдралыг өөрчлөхийн төлөө хамтдаа зүтгэх гишүүд улам олон болно.
- Илүү үр ашигтай, илүү цар хүрээтэй төслүүдийг хэрэгжүүлнэ.

### РОТАРИЧУУД НЭМЭГДСЭЭР: 3 САРЫН ДОТОР 25 ШИНЭ РОТАРИЧУУД НЭГДЛЭЭ

| Ротарийн жил | 2014-2015 | 2015-2016 | 2016-2017 | 2017-2018 | 2018-2019 | 2019-2020 | 2020-2021 | 2020-2022 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Нийт гишүүдийн тоо | 261 | 289 | 320 | 318 | 352 | 350 | 339 | 373 |
| Гишүүнчлэлийн өсөлтийн хувь | | 10.70% | 10.70% | -1% | 11% | -0.53% | -3.14% | 9.11% |




| 2021-2022 9-р Бүс | 7 сарын 1 | Шинээр нэмэгдсэн | 9 сарын 31 |
|---|---|---|---|
| Улаанбаатар | 25 | 0 | 25 |
| Өргөө | 12 | 0 | 12 |
| УБ Пийс Авеньюу | 28 | 1 | 29 |
| Нарлаг УБ | 19 | 3 | 22 |
| Номт | 20 | 0 | 20 |
| УБ Хангарьд | 19 | 1 | 20 |
| Баянзүрх | 8 | 0 | 8 |
| Тэнгэр | 19 | 4 | 23 |
| **Нийт** | 150 | 9 | 159 |

| 2021-2022 10-р Бүс | 7 сарын 1 | Шинээр нэмэгдсэн | 9 сарын 31 |
|---|---|---|---|
| Хүрээ | 35 | 0 | 35 |
| Нийслэл | 20 | 3 | 23 |
| Зуунмод | 9 | 8 | 17 |
| Туул | 31 | 6 | 37 |
| Сэлбэ | 14 | 0 | 14 |
| Тамир | 16 | 0 | 16 |
| Сэлэнгэ | 23 | 3 | 26 |
| УБ Централ | 20 | 2 | 22 |
| Гэрэгэ | 21 | 3 | 24 |
| **Нийт** | **189** | **25** | **214** |

### Улирал тутмын Шинэ болон Сонирхогч гишүүдэд зориулсан уулзалт

2021 оны 8-р сарын 21 өдөр Гишүүнчлэлийн хороо, Бүсийн Удирдлага, Бүсийн Захирагчид хамтран шинэ гишүүд болон сонирхогч нарт зориулан сургалт зохион байгуулж эхэлсэн байгаа. Нийт 29 Ротаричууд болон Ротарийг сонирхсон хүмүүс оролцсон юм. Уг уулзалтыг улиралд нэг удаа хийхээр төлөвлөж байгаа.



### Ротарид Тавтай Морилно уу: Манай Шинэ Ротаричууд

















# ОНЦЛОХ ТӨСӨЛ: ХҮРЭЭ РОТАРИ КЛУБЫН "ЗҮРХНЭЭС ЗҮРХ" ТӨСӨЛ

## ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДЭСЛЭЛ

- Монгол улсад жилд дунджаар 70000 нярай төрдөг бөгөөд эдгээрийн 350 (бүртгэгдсэн 50 орчим) орчим нь зүрхний төрөлхийн гажигтай(Congenital heart disease) төрдөг
- Зүрхний төрөлхийн гажигтай төрсөн нярай хүүхдүүдийн 25 орчим хувь буюу 4 нярайн нэг нь амьдралынхаа эхний 1 сар дотроо зүрхний нээлттэй мэс заслын(open heart surgery) болон судсан дотуурх эмчилгээ (catheter intervention treatment) яаралтай шаардлагатай хүүхдүүд байдаг.
- Одоогоор зүрхний нээлттэй мэс засал хийдэггүй учраас эдгээр нярай хүүхдүүд амьдралын эхний 1 сардаа эндэж байна.
- Ротарийн санхүүжилтээр гадагшаа хүүхдүүдийг эмчилгээнд явуулсан байдал
  - Туул ротари клуб 315 хүүхэд
  - Хүрээ ротари клуб 3 удаагийн төслөөр 25 хүүхэд
- **Хэдий болтол гадагшаа хүүхдүүдээ явуулж, хүний газрыг царайчлах вэ????**

Эдгээр нярай хүүхдүүдийг аврах боломж нь зүрхний нээлттэй мэс заслын эмчилгээ юм. Уг эмчилгээг цаг алдалгүй хийж чадвал нярайн амь насыг аврах бүрэн боломжтой. Иймд ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн эмнэлэг дээр нярайн зүрхний нээлттэй мэс заслыг чадамжийг бэхжүүлэх зайлшгүй шаардлагатай байгаа нь уг төслийг хэрэгжүүлэх үндэслэл болж байна.

## ОДООГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

- Гадагш эмчилгээнд явуулах (Коронагаас явж чадахгүй байгаа) Солонгост 150 сая төг
- Сонгдо эмнэлэгт 15 сая (50% даатгал)
- Гаднаас эмч нар аппарат хэрэгсэлтэйгээ ирж хагалгаа хийх (Коронагаас болоод боломжгүй)
- 3-р эмнэлэгт тодорхой наснаас дээших хүүхдүүдэд цөөн хагалгаа хийдэг.
- ЭХЭМҮТ-ийн хяналтанд 2752 хүүхэд, яаралтай хагалгаа шаардлагатай 814 хүүхэд байна. Зүрхний эмч нарын баг бэлэн.
- Хүүхдийн кардиолог-6, ангиографийн эмч-2, зүрхний мэс заслын эмч-1, хүүхдийн анестезиолог-11, нярайн сэхээн амьдруулалтын эмч-12, мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээний эмч-4, хүүхдийн эрчимт эмчилгээний эмч-5, анестезиологийн сувилагч-10, нярайн сэхээний сувилагч-15, кардиолог сувилагч-5 бэлтгэгдсэн байна. Эдгээрээс Япон улсад мэргэжил дээшлүүлсэн-5, Солонгос улсад мэргэжил дээшлүүлсэн-8 байна.

*Монголын Ротари Клубууд Хамтран Ажиллахыг Урьж байна.*



*project heart-to-heart*

**Хамтрах Клубууд:** Хүрээ, Туул, Тамир, Сэлэнгэ, Сэлбэ

## ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

| Project name | Hearts to hearts |
|---|---|
| Community assessment | Done |
| Budget | Under quotation |
| Funding | Under negotiation with Japanese Clubs and Districts |
| Cooperating organization | Mother and Child Hospital (State owned)<br>(Invested 1M USD for surgery equipment, depends on state budget, so some of the necessary equipment is not ready, have surgery team, no operation was done because of equipment)<br>Health insurance coverage 100% |
| Project activity | Providing remained necessary equipment for congenital heart disease surgery<br>OTJ for young doctors. |
| MOU | Not yet |
| Application | Not yet (After decision the project budget and funding sources) |
| Monitoring and evaluation Plan | Not yet |
| DDF | Planning to apply |
| Submission planned period | Jan-22 |


Rotary
District 3450
Rotaract
District 3450
Interact
District 3450
SERVE TO CHANGE LIVES
ЭМЧ, СУВИЛАГЧ НАРТАА
БАЯРЛАЛАА

# 9, 10-Р БҮСИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХОРОО

- Цус Хандивлах Аян
- Зүрх Амьсгалын Сэхээн Амьдруулалтын сургалтын төсөл
- Эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээг дэмжих болон олон нийтэд таниулах чиглэл
- Эрүүл мэндийн өвчнөөс урдчилан сэргийлэх болон эмчлэх чиглэлийн бусад төсөл хөтөлбөрүүдийг дэмжих үйл ажиллагаанууд

## ЦУСАА ХАНДИВЛАХ АЯН

- 2021-22 оны Ротари жилийн дүүргийн, бүсийн Гол чиглэлийн Нэг бол Эрүүл мэнд бөгөөд тэр дундаа Цусаа хандивлах аян юм. Монголын 9, 10-р Бүсийн Ротари болон Ротаракторууд бид уг аянг эхлүүлэнгээ сар болгоны 3-ний өдөр цусаа хандивлахыг уриалж байна. Манай Зуунмод Ротари клуб уг аянг идэвхтэй дэмжиж оролцож байгаа.




## CPR/ AED – ЗҮРХ АМЬСГАЛЫН СЭХЭЭН АМЬДРУУЛАЛТЫН СУРГАЛТЫН ТӨСӨЛ

Юу: Улаан Загалмай Монгол байгууллагатай хамтран 2021-10-25 аас эхлэн 100 Ротари гишүүдэд зориулан Зүрх Амьсгалын Сэхээн Амьдруулалтын сургалтын зохион байгуулахаар болсон байгаа.

Сургалтын багц:

- 2 цаг цахим сургалт
- 8 цаг дадлагын сургалт
- Бүх сургах тоног төхөөрөмжүүд болон ОУ-д бэлтгэгдсэн сургагч багш нар
- Улаан Загалмай Монгол байгууллагын төв оффис дээр хагас сайн өдөр бүр дадлага хичээл явагдана
- 115,000₮ нэг хүний багц



# ОНЦЛОХ ТӨСӨЛ: УБ ПИЙС АВЕНЬЮ КЛУБЫН “ЭХ БАРИХ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭМНЭЛЗҮЙН УР ЧАДВАРЫН СУРГАЛТЫН ТӨВ”



Улаанбаатар Пийс Авенью Ротари клуб нь Олон Улсын Ротари Сангийн санхүүжилтээр нийт 189,000 ам.доллар буюу 538.6 сая төгрөгийн өртөг бүхий Монголын анхны бүрэн компьютержсэн "Эх барих эмэгтэйчүүдийн эмнэлзүйн ур чадварын сургалтын төв (First Birthing Simulation Center)" байгуулах төслийн эхний үе шатыг амжилттай хэрэгжүүлж дууслаа.

Судалгаагаар эхийн эндэгдлийн дөрөвний гурав нь жирэмсний болон төрөх үеийн хүндрэлээс шалтгаалдаг байна. Эх хүүхэд эсэн мэнд амаржихад хамгийн чухал зүйлийн нэг нь төрөлт бүрийг эх барихын ур чадвартай эмнэлгийн мэргэжилтэн эх барьж, яаралтай үед зохих шатны эх барихуйн шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлэх юм. Монгол улс нь эхийн эндэгдэлийг бууруулах мянганы хөгжлийн зорилтыг хэрэгжүүлсэн цөөн хэдэн улсын нэг болсон ч тогтвортой биш байна. Тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд 2030 он гэхэд сэргийлж болох эхийн эндэгдлийг тэглэх зорилт тавьсан энэ үед бид эх барихын тусламж үйлчилгээ үзүүлэгчдийг чадавхижуулах, мэргэжил дээшлүүлж буй, мэргэжил олгох сургалтанд хамарагдаж буй резидент, шинэ төгссөн эмч нар болон эх баригч нарын эх барихын тусламж үзүүлэх ур чадварыг сайжруулах үүднээс АШУҮИС-ийн АУС-ийн Эх барих эмэгтэйчүүд судлалын тэнхимийн дэргэд дууриамал орчинг бүрдүүлсэн сургалтын төв байгуулж байгаадаа их баяртай байна. Орчин үед хүний эрхийн асуудалтай холбоотой бодит орчинд эмнэлзүйн дадлага хийх боломж улам бүр багассаар байгаа билээ.

Энэхүү "Эх барих эмэгтэйчүүдийн эмнэлзүйн ур чадварын сургалтын төв" нь эх барих эмэгтэйчүүдийн эмч, эх баригч, сувилагч, хүүхдийн эмч, дадлагажигч эмч, оюутнуудад эх барихын



эмнэлзүйн сургалт явуулах дууриамал орчинг бүрдүүлж төрөх тусламж, кесар болон умай авах мэс засал, төрсний дараах цус алдалтын үед тусламж үзүүлэх, жирэмсний оношлогоо зэрэг төрөх үеийн хүндрэлүүдийг багаар үзүүлэх сургалтуудыг бодиторчинд компьютержсэн тоног төхөөрөмжүүд ашиглан зохион байгуулах юм.

Төслийн эхний шатанд Эх барих эмэгтэйчүүдийн эмнэлзүйн ур чадварын сургалтын төвд хүлээн авах яаралтай тусламжийн өрөө, дүрс оношлогооны өрөө, төрөх өрөө, мэс заслын өрөө гэсэн 4 үндсэн тусламжийн дууриамал орчинг бүрдүүллээ. Мөн эх барих бусад тусламж, мэс ажилбарыг бичлэгээр дэлгэцээр үзүүлэх сургалтын өрөөг бүрэн тоногжуулан тохижуулж өглөө. Төслийн хоёр дахь шатанд бид мэргэжилтэн солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх юм. АНУ-аас мэргэжилтнүүд авчирч сургалт зохион байгуулах, мөн Монголоос дөрвөн мэргэжилтнийг АНУ-д ур чадварын сургалтын төвүүдээр зочлуулан, энэхүү төвийг хэрхэн амжилттай явуулах талаар хоёр долоо хоногийн дадлага сургалтанд хамруулна.

Олон Улсын Ротари Сангийн санхүүжилтээр хэрэгжиж буй тус төслийн зорилго нь цаашид Монгол Улсад сурч боловсорч буй эх барих эмэгтэйчүүдийн эмч, сувилагч, оюутнуудад эх нялхсын эрүүл мэндийн чиглэлээр үндэсний болон олон улсын стандартад нийцсэн боловсрол мэргэжил эзэмшүүлэн, бэлтгэгдсэн ур чадвар бүхий мэргэжилтэн бэлтгэх, улмаар төрөлтийн хүндрэлийн эрсдэл, эхийн болон нярайн эндэгдлийг бууруулахад хувь нэмэр оруулах явдал юм.



# 9, 10 БҮСИЙН РОТАРИГ ОЛОН НИЙТЭД ТАНИУЛАХ ХОРОО

**БИД ЯАГААД РОТАРИГ БОЛОН ХИЙЖ БАЙГАА АЖЛУУДАА ОЛОН НИЙТЭД ТАНИУЛАХ, ТҮГЭЭХ, СУРТАЛЧИЛАХ НЬ ЗҮЙТЭЙ ВЭ?**

- Шинэ ГИШҮҮД элсүүлэх
- Шинэ ТӨСЛИЙН санаа хөгжүүлэх
- Шинэ ХАМТРАГЧИДТАЙ болох
- Сайн САЙХАН ЗҮЙЛИЙГ түгээх
- Хийсэн төслөө таниулж ҮР ӨГӨӨЖИЙГ нь олон хүнд ХҮРГЭЖ ТУС болох
- Өөсддөө ТАЛАРХАХ болон бусдад талархах боломж олгох

## БИДНИЙ ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАЖ БУЙ СУВГУУД

**1. ОЛОН УЛСЫН ХҮРЭЭНД:**
- MyRotary https://my.rotary.org/en
- Rotary International Facebook хуудас: https://www.facebook.com/rotary

**2. ДҮҮРГИЙН ХҮРЭЭНД**
- Дүүргийн вэбсайт: https://rotary3450.org/
- Rotary International District 3450 Facebook хуудас: https://www.facebook.com/Rotary3450
- DG Онлайн сонин: http://dg-newsletter.rid3450.org/

*Сар бүрийн 5-ний дотор өмнөх сарын мэдээ мэдээллийг зураг болон видеогоор salimabolor@gmail.com хаяг руу илгээх*

**3. БҮСИЙН ХҮРЭЭНД**
- Бүх гишүүдийн ГРУПП /хаалттай/ Mongolian Rotary Clubs Members: https://www.facebook.com/groups/539691572738697
- Олон нийтийн PAGE /нээлттэй/ Mongolian Rotary Clubs: https://www.facebook.com/RotaryMongolia
- Бүсийн вэбсайт: http://rotarymongolia.org/
- Youtube channel: Rotary Mongolia
- Бүсийн Цахим сонин

**4. КЛУБЫН ХҮРЭЭНД**

Клуб болгон өөрийн Facebook болон Instagram хуудастай болох
Боломжтой бол өөрийн вэбсайттай болох

## РОА ЗУРАГ БОЛОН ВИДЕОНЫ УРАЛДААН ЭХЭЛЛЭЭ

Уралдаанд илгээж буй зураг нь дараахь зүйлсийг агуулсан байх:

1. TOGETHER, WE лого слоган
2. Зургийн Нэр
3. РоА лого
4. РК ......../клубын нэр/

Зургаа бэлэн болгоод доорхи QR кодоог татаж авах:

**1-Р ҮЕ: ЗУРАГ БОЛОН ВИДЕОГ 9 САРЫН 18-ААС 11 САРЫН 26 ХҮРТЭЛ ИЛГЭЭХ**

Анхаарах зүйлс:
Албаны групп зураг бус, Төсөл болон Ажил хийж буй зураг
Зурагны чанар /чатаар авсан, сошиалаас авсан зургны чанар мууддаг тул ориг зургийг ашиглах/
Rotary Brand Center –ээс лого болон слогануудыг авах

**PUBLIC IMAGE**
Building Your Online Presence

Rotary | SERVE TO CHANGE LIVES

# ОНЦЛОХ ТӨСӨЛ: НАРЛАГ УЛААНБААТАР РОТАРИ КЛУБЫН "ШИНЖЛЭХ УХААНЫ ЛАБОРАТОРИ ДУГУЙЛАН БАЙГУУЛАХ" ТӨСӨЛ



**2021-2022 оны Ерөнхийлөгч Б.Долгорсүрэн**

"Боловсрол" нь Монгол Улсын эдийн засгийн өсөлт, нийгмийн стратегийн салшгүй нэг хэсэг юм. Монгол Улсад анхан шатны боловсролыг олгодог бага сургуулиудад байгалийн шинжлэх ухааны хичээлийг ихэвчлэн онолын мэдлэг дээр тулгууран ордог бөгөөд туршилт хийх, практик заах аргууд дутмаг байдаг. Тиймээс сурагчдыг бага ангиас нь байгалийн шинжлэх ухааны туршилтыг хийх боломжийг олгох зорилгоор "Нарлаг Улаанбаатар" Ротари клуб нь 2018-2020 онд  Олон Улсын Ротари Сан, Нагаока Ийст Ротари Клуб, Ротарийн 2560 дүүрэгтэй хамтран Шинжлэх ухааны лаборатори дугуйлан байгуулах 66,000 долларын санхүүжилт бүхий Глобал Грант (GG1862252) төслийг хэрэгжүүлж, Science Experiment Laboratory буюу 3-6 ангийн хүүхдүүдэд зориулсан байгалийн шинжлэх ухааны иж бүрэн лаборатори дугуйланг Монголын Хүүхдийн ордон дээр байгуулсан билээ.



SCIENCE EXPERIMENT LAB – 2 ТӨСӨЛ

2021-2022 онд энэхүү төслийн 2 дах үе шатыг хэрэгжүүлж Улаанбаатар хот болон орон нутгийн 3 сургууль дээр иж бүрэн шинжлэх ухааны дугуйлан байгуулах, 1 сургууль дээр арга зүйн дэмжлэг үзүүлэхээр ажиллаж байна.

Төслийн хүрээнд сургууль бүрт туршилтын багаж, тоног төхөөрөмж, ширээ, сандал гэх мэт тавилгаар хангах мөн багш нарын сургалтын үйл ажиллагаанууд багтана. Бага ангийн боловсролын хөтөлбөрийг баяжуулах зорилгоор багш нарт зориулсан гарын авлага, туршилтын видео хичээлийг бэлтгэн вэб сайтад байршуулсан бөгөөд Японы бага сургуулийн байгалийн шинжлэх ухааны хичээлийн хөтөлбөрийг ашиглаж, туршилтад тулгуурлан хичээлээ орох юм. Төслийн өртөг $45,000,000



# 9, 10-Р БҮСИЙН РОТАРИ САНГИЙН ХОРОО
## ГРАНТ МЕНЕЖМЕНТИЙН СЕМИНАР

2021 оны 8 сарын 25-ний өдөр 3450 Дүүргээс зохион байгуулсан Грант Менежментийн Семинарт 15 клубын Сангийн хорооны дарга нар болон гишүүд оролцож Дүүргийн болон Глобал Грантын тухай ойлголт болон бусад хэрэгцээт мэдээ мэдээллийг авсан байгаа. Дүүргийн болон Глобал Грантын тэтгэлэг авах өргөдөл гаргаж байгаа бол энэхүү Семинар заавал суух сургалт юм.





### ДҮҮРГИЙН БОЛОН ГЛОБАЛ ГРАНТ ТЭТГЭЛЭГИЙН БОЛЗОЛ 1

Дүүргийн болон Глобал Грант тэтгэлэгт өргөдөл гаргах болзолыг хангахад дараах бичиг баримуутдыг бүрдүүлж өгдөг байгаа. Манай клубууд бүгд хугацаандаа шуурхай ажилласан.

| No | Клуб | ГМС онлайн серфикит | MOU DG | MOU GG | FMP for DG | FMP for GG |
|---|---|---|---|---|---|---|
| AREA 9 | | | | | | |
| 1 | Улаанбаатар | Yes | Yes | Yes | Yes | Yes |
| 2 | Өргөө | Yes | Yes | Yes | Yes | Yes |
| 3 | УБ Пийс Авенью | Yes | Yes | Yes | Yes | Yes |
| 4 | Нарлаг УБ | Yes | Yes | Yes | Yes | Yes |
| 5 | Номт | Yes | Yes | Yes | Yes | Nil |
| 6 | УБ Хангарьд | Yes | Yes | Yes | Yes | Yes |
| 7 | Баянзүрх | Yes | Yes | Yes | Yes | Yes |
| AREA 10 | | | | | | |
| 1 | Хүрээ | Yes | Yes | Yes | Yes | Yes |
| 2 | Нийслэл | Yes | Yes | Yes | Yes | Yes |
| 3 | Зуунмод | Yes | Yes | Yes | Yes | Yes |
| 4 | Туул | Yes | Yes | Yes | Yes | Yes |
| 5 | Сэлбэ | Yes | Yes | Yes | Yes | Yes |
| 6 | Тамир | Yes | Yes | Yes | Yes | Yes |
| 7 | Сэлэнгэ | Yes | Yes | Yes | Yes | Yes |
| 8 | УБ Централ | Yes | Yes | Yes | Nil | Yes |
| 9 | Гэрэгэ | Yes | Yes | Yes | Yes | Yes |

### ДҮҮРГИЙН БОЛОН ГЛОБАЛ ГРАНТ ТЭТГЭЛЭГИЙН БОЛЗОЛ 2

Ротари Сангийн төсвийн бүрдүүлэлт нь Гишүүн Бүр Жил Бүрийн хандиваар санхүүждэг юм. Тиймээс бид Гишүүн бүрийн тоогоор 100$ хандивлаж урт удаан хугацаанд олон төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлч хэрэгжүүлэх боломжтой болдог юм.

The Rotary Foundation

EVERY ROTARIAN EVERY YEAR

# ОЙРЫН ХУГАЦААНД БОЛ

## ОУ Ротарийн Ерөнхийлөгчийн Нэрэмжит Азийн Конференц

Манила, Филиппинид 11 Сарын 26-28 Хооронд Цахимаар Болно.




**100% Клубийн бүх Гишүүдээрээ бүртгүүлсэн Нарлаг Улаанбаатар болон Тамир Ротари клубуудэд болон бүх Ротари Гишүүдэд БАЯРЛАЛАА**










**Монголоос оролцож буй зочин Спикер Др. Оюун**

# ЮХ АРГА ХЭМЖЭЭНҮҮД:

## END POLIO АЛХАЛТ: 11 сарын 6нд, Бямба гариг




**9, 10 Бүсийн бүх Клубуудын нэрийн өмнөөс End Polio хандив өгсөн AG Мягмаржаргал болон AG Болормаа нартаа БАЯРЛАЛАА**

2021-22 оны Ротарийн жилд "End Polio" Санд клуб бүр 50$ -ын хандив өгөх уриалгыг дэмжин бидний зүгээс нийт Монголын 17 клубынхээ нэрийн өмнөөс уг хандивын нийт дүн 850.0$-ыг 2021-09-30 ны өдөр Олон Улсын Ротарийн END POLIO санд шилжүүллээ. Ингэснээр энэхүү "Саа өвчнийг устгах Ротаричуудын" жил бүрийн аянд Монголын Ротаричууд энэ жил 100 хувь нэгдэж чадлаа. Та бүхнийг ирэх жилүүдэд илүү их хандив өргөж сайн үйлсийн аяныг үргэлжлүүлэн явна гэдэгт итгэлтэй байна. Баярлалаа.

**Хүндэтгэсэн,**
A 9 AG Мягмаржаргал Н    A10 AG Болормаа Т